ХОТ БАЙГУУЛАЛТ,
ХӨГЖЛИЙН ГАЗАР

ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС

# 2021 ОНЫ
# АЖЛЫН ТАЙЛАН



***БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:***

1.1 Дүүрэг бүрд барих эрүүл мэндийн төвийн барилга байгууламжийн хүсэлтийг шийдвэрлэх.

- Хан-Уул, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Багануур дүүргийн архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан.
- Баянгол, Сонгинохайрхан, Налайх, Багахангай дүүрэгт барилга барих хүсэлт ирээгүй тул Эрүүл мэндийн яам болон нийслэлийн эрүүл мэндийн газарт Эрүүл мэндийг дэмжих нийгмийн дэд бүтцийг нэмэгдүүлэх дээрх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулахад хот төлөвлөлт, хот байгуулалтын чиглэлээр тулгамдаж байгаа асуудлаар санал ирүүлэн хамтран ажиллах тухай 2021 оны 06 сарын 07-ны өдрийн 03/1631 дугаартай албан бичиг хүргүүлж ажиллав.

1.2 Нийслэлийн Наркологийн эмнэлгийн барилгын Барилга барих хүсэлтийг журмын дагуу шийдвэрлэх

Хүсэлт ирүүлээгүй тул эрүүл мэндийн яам болон нийслэлийн эрүүл мэндийн газарт Эрүүл мэндийг дэмжих нийгмийн дэд бүтцийг нэмэгдүүлэх дээрх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулахад хот төлөвлөлт, хот байгуулалтын чиглэлээр тулгамдаж байгаа асуудлаар санал ирүүлэн хамтран ажиллах тухай 2021 оны 06 сарын 07-ны өдрийн 03/1631 дугаартай албан бичиг хүргүүлээд байна.



1.3 Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт нэгдсэн эмнэлэг Барилга барих хүсэлтийг журмын дагуу шийдвэрлэх

- Хан-Уул дүүргийн 04 дүгээр хороонд МЗХ2021/20-001 дугаартай Архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан бөгөөд загвар зураг батлуулах хүсэлт ирээгүй.

1.4 Баянзүрх дүүрэгт төрийн өмчийн нэгдсэн эмнэлэг Барилга барих хүсэлтийг журмын дагуу шийдвэрлэх

- Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороо, “Да хүрээ” авто захын баруун хойд талд, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын эзэмшил газарт нэгдсэн эмнэлэг барих хүсэлт ирүүлснийг судлан Мэргэжлийн зөвлөлийн 22 дугаар хуралд танилцуулан зөвшөөрөгдөж МЗХ2021/22-010 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар батлуулсан.

1.5 Цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх хүсэлтийг шийдвэрлэх

Тайлант хугацаанд 19 байршилд Архитектур төлөвлөлтийн даалгавар, 12 байршилд загвар зураг батлагдсан.

1.6 Сургуулийн барилгыг шинээр барих, өргөтгөх хүсэлтийг шийдвэрлэх

Тайлант хугацаанд 19 байршилд архитектур төлөвлөлтийн даалгавар, 5 байршилд загвар зураг батлагдсан.







1.7 Түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг шинэчлэх ажлыг эхлүүлнэ. /Фасад, тохижилт шинэчлэх хүсэлтийг шийдвэрлэх/

- Налайх дүүргийн 03 дугаар хороо, Мэргэн Тоньюкукийн гэрэлт хөшөө орчимд "Мэргэн Тоньюкукын музей" Соёл, аялал жуулчлалын цогцолборын МЗХ2021/07-014, МЗХ2021/07-015 дугаар архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлагдсан.
- Чингэлтэй дүүргийн 05 дугаар хороо, Тасганы овооны орой орчимд Шашин соёл, аялал жуулчлалын цогцолборын МЗХ2021/08-07 дугаар архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлах ажлыг зохион байгуулав.
- Чингэлтэй дүүргийн 3, 4, 5, 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах хуучин орон сууцны 14 барилгын гадна дулаалга, фасадын өнгө өөрчлөн сэргээх зураг төслийг хэрхэн боловсруулах талаар танилцуулга бэлтгэж зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

1.8 Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан цэцэрлэгт хүрээлэн байгуулж, олон нийтийн амралт зугаалгын талбайг нэмэгдүүлнэ.

- Баянзүрх дүүргийн 20, 23, 28 дугаар хороонд, Гачууртын замын урд талаар цэцэрлэгт хүрээлэн байгуулах зориулалтаар 55.4 га талбайд тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлагдсан.

- Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд, Баянзүрхийн товчооны шинэ гүүрний баруун талд, цэцэрлэгт хүрээлэн байгуулах зориулалтаар 10.5 га талбайд тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлагдсан.
- Баянзүрх дүүргийн 20 дугаар хороонд, Баянзүрхийн товчооны гүүрний зүүн талд, цэцэрлэгт хүрээлэн байгуулах зориулалтаар 1.6 га талбайд тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлагдсан.
- Баянзүрх дүүргийн 12 дугаар хороонд, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 18.0 га талбайд тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар, загвар зураг зөвшилцөж батлуулсан.
- Баянзүрх дүүргийн 27 дугаар хороонд Дарь Эх цогцолбор орчимд цэцэрлэгт хүрээлэн байгуулах зориулалтаар 43.0 га талбайд тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлагдсан

1.9 Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг үргэлжлүүлнэ.

- Нийслэлийн концесийн гэрээгээр хэрэгжүүлэх Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн баруун хаалганы авто зогсоолын загвар зургийг зөвшилцөж, батлуулсан.
- Зэвсэгт хүчний Жанжин штабын захиалгаар хийгдэх “Монгол цэрэг энхийн төлөө дурсгалт цогцолбор”-ын тохижилтын загвар зургийг зөвшилцөж, батлуулсан.
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны нэрэмжит тохижилт хийх асуудлыг судлан Мэргэжлийн зөвлөлийн 10 дугаар хуралд хэлэлцүүлэн зөвшөөрөгдөж МЗХ2021/10-009 дугаартай тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлуулсан.
- Рагби болон бэйсболын талбай байгуулах асуудлыг судлан Мэргэжлийн зөвлөлийн 10 дугаар хуралд хэлэлцүүлэн зөвшөөрөгдөж МЗХ2021/10-008 дугаартай тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлуулсан.
- Хот байгуулалт, хөгжлийн газрын нэрэмжит тохижилтын ажлын загвар зураг батлуулсан. Мөн бүтээн байгуулалтын ажилд идэвхтэй оролцов.

1.10 Нийтийн эзэмшлийн гудамж талбай ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх

- Нийтийн эдэлбэр газарт тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар авах 15 байршлыг судалж Мэргэжлийн зөвлөлийн хурлаар байршлыг хэлэлцүүлэн тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлагдсан.
- 2 байршилд явган хүний зам талбайн тохижилтын загвар зураг зөвшилцөж батлуулсан.

1.11 Иргэд, олон нийтэд биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, амарч зугаалах тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор стандартад нийцсэн спорт хүүхдийн тоглоомын талбайг байгуулах,

- Хүүхдийн тоглоомын талбай байгуулах 10 байршлыг судалж Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлагдсан.
- 1 байршилд биеийн тамир, спортын талбайн загвар зураг зөвшилцөж, батлуулсан.
- Сүхбаатар дүүргийн 18-р хороо Дамбадаржаагийн гудамжны зүүн талд хүүхдийн тоглоомын талбайн ГБМЗХ2020/25-025 дугаарт тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгаврын дагуу загвар зураг батлагдсан.

1.12 Эмнэлгүүдийн гаднах зам талбайг тохижуулах

Цэргийн төв эмнэлгийн гадна талбайг тохижуулах хүсэлтийг судалж Мэргэжлийн зөвлөлийн хурлаар байршлыг хэлэлцүүлэн тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлагдсан. Батлагдсан даалгаврын хүрээнд боловсруулсан загвар зургийг зөвшилцөж, батлуулсан.

- Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлгийн гадна тохижилтын зураг 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан.

1.13 Сургууль, цэцэрлэгийн гадна талбайг тохижуулах

- 69 дүгээр сургуулийн гадна талбайг тохижуулах хүсэлт ирүүлсний дагуу Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн шийдвэрийн дагуу

тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар боловсруулж, батлуулсан. Батлагдсан даалгаврын хүрээнд боловсруулсан загвар зургийг хянан зөвшилцөж, батлуулсан.

- 111 дүгээр сургуулийн гадна талбайг тохижуулах хүсэлт ирүүлсний дагуу Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн шийдвэрийн дагуу тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар боловсруулж, батлуулсан.
- 82 дугаар цэцэрлэг, 267 дугаар цэцэрлэгүүдийн гадна талбайг тохижуулах хүсэлт ирүүлсний дагуу Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн шийдвэрийн дагуу тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар боловсруулж байна
- 2 байршилд загвар зураг зөвшилцөж, батлуулсан.
- Чингэлтэй дүүргийн 03 дугаар хороо, 19 дүгээр цэцэрлэгийн гадна талбайн тохижилтын ажлын МЗХ2021/03-012 дугаартай төлөвлөлтийн даалгавар батлагдаж мөн загвар зураг нь 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр батлагдсан.
- Сүхбаатар дүүргийн 01 дүгээр хороо, Анагаахын Шинжлэх Ухааны Их сургуулийн гадна тохижилтын МЗХ2021/06-022 дугаартай тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлагдсан.
- Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хороо, Ерөнхий боловсролын 35 дугаар сургуулийн гадна тохижилтын МЗХ2021/09-043 дугаартай тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлагдсан.
- Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хороо, 51 дүгээр цэцэрлэгийн гадна тохижилтын МЗХ2021/09-044 дугаартай тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлагдсан.
- Чингэлтэй дүүргийн 224 дүгээр цэцэрлэгийн МЗХ2021/11-017 дугаартай тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлагдсан.

1.14 Туул, Сэлбэ, Дунд голын урсцыг нэмэгдүүлж, эргийн дагуу олон нийтийн соёл, амралтад зориулсан тохилог орчныг бүрдүүлэх

- Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд, Туул голын эргийн тохижилт байгуулах зориулалтаар 3 байршилд, 10.3 га талбайд тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлагдсан. Тус тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгаврын дагуу “Туул гол дагуу амралт, зугаалгын цогцолбор байгуулах төслийн концепц, загвар зураг боловсруулах уралдаан” зохион байгуулагдсан. загвар зургийг зөвшилцөж батлуулсан.
- Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороо, Сэлбэ гол дагуух унадаг дугуйн замын төлөвлөлтийн даалгаврын дагуух 1.6 км дугуйн замын загвар зураг, ГБМЗХ2020/20-003 дугаарт сэлбэ гол дагуух амралтын талбайн тохижилтын загвар зураг батлагдсан.
- Сүхбаатар дүүргийн 13,14,15,16,17,18,20 дугаар хороо, Сэлбэ гол дагуух унадаг дугуйн замын төлөвлөлтийн даалгаврын дагуух 5.0 км дугуйн замын загвар зураг, ГБМЗХ2020/20-003 дугаарт сэлбэ гол дагуух амралтын талбайн тохижилтын загвар зураг батлагдсан

***ХОЁР . ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД***

1 Барилга, байгууламж болон нийтийн эдэлбэр газрын тохижилтын ажлын архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах, олгосон зөвшөөрлийн хүрээнд хяналт тавих,

Мэргэжлийн зөвлөлийн хурлаар давхардсан тоогоор 858 хүсэлтийг хэлэлцүүлэн 687 дэмжигдсэн тул 80,1 хувьтай гарч байна.

Хурлаар хэлэлцүүлсэн материалыг төрөлжүүлэн харуулбал:

- Барилга байгууламж 591/425 буюу 71.9 хувь
- Авто зам замын байгууламж 65/64 буюу 98.4 хувь
- Тохижилтын ажил 202/198 буюу 98.0 хувь












2 Хөшөө, хүндэтгэлийн самбарыг хот төлөвлөлтөд уялдуулан уран сайхны шийдэл гаргах, үндэсний архитектурт нийцүүлж шинээр байршуулах, шилжүүлэх ажиллагааг зохион байгуулж, НИТХ-ын тогтоол гаргуулах

- “Улсын нийслэлд хөшөө, дурсгал хүндэтгэлийн самбар байрлуулах журам”-ын дагуу Монголын төр нийгэм, соёл, гэгээрэл, шинжлэх ухааны нэрт зүтгэлтэн, гоо зүй утга зохиолын судлаач, доктор, профессор, БНМАУ-ын Соёлын яамны нэгдүгээр орлогч сайд асан Содномын Лувсанвандан, Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн Бөхийн Баастын хүндэтгэлийн самбар

байршуулах асуудлаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн № 40 тогтоол батлагдсан.

- 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Хөшөө дурсгал хүндэтгэлийн самбар байршуулах загвар батлах комиссын хурлаар доорх 5 материалыг хэлэлцүүлж Лев Николаевич Гумилёвын нэрэмжит хөшөө байршуулах асуудал дэмжигдсэн.

  1. Атилла хааны хөшөө
  3. Сүрэнжав  хүндэтгэлийн самбар
  4. Мозайкын хамгаалалт
  5. “Эхлэл” дурсгалын самбар

Тайлант хугацаанд ирсэн 7 хүсэлтийн 2 нь тогтоол гарч эцэслэн шийдвэрлэгдсэн, 5 асуудал комиссын хурлаар шийдвэрлэсэн. 1 асуудал судлагдаж байна. Шийдвэрлэлт 78,5 хувьтай

3 Шинээр барих өргөтгөх авто зам замын байгууламжийн хүсэлтийг  хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн авто зам замын байгууламж төлөвлөх даалгавар боловсруулж, загвар зураг зөвшилцөх, баталгаажуулах,




Тайлант хугацаанд нийт 64 материалыг бэлтгэн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 63 асуудал дэмжигдсэн бөгөөд 98.4 хувийн үзүүлэлттэй байна.

4 Загвар зураг /эскиз/ батлах, хүчинтэй хугацааг сунгах

- Тайлант хугацаанд нийт 372 загвар зураг ирснээс 282 загвар зургийг баталсан.  90 загвар зургийг холбогдох хууль, норм ба дүрэм журам стандартын шаардлага хангуулахаар буцаасан.

Шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

| д/д | ЗАГВАР ЗУРАГ | ХУД | БЗД | БГД | СБД | ЧД | СХД | А-3 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Нийт ирсэн хүсэлт | 140 | 65 | 41 | 32 | 8 | 42 | 37 | 372 |
| 2 | Хүчинтэй эсэхийг хэлэлцүүлэх | 2 | 0 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 4 |
| 3 | Албан бичгээр хариу өгсөн | 10 | 2 | 2 | 2 | 0 | 1 | 1 | 18 |
| 4 | Батлагдсан | 97 | 50 | 40 | 23 | 8 | 30 | 30 | 282 |
| 5 | Судлах, зөвшилцөх шатанд байгаа /буцаагдсан/ | 43 | 15 | 4 | 9 | 0 | 12 | 7 | 90 |

Үүнээс: Зориулалтаар нь ангилж үзүүлбэл:

| № | Батлагдсан загвар мэдээлэл | Тоо |
|---|---|---|
| 1 | Барилга | 243 |
| 2 | Авто зам | 9 |
| 3 | Тохижилт | 30 |
| | Нийт | 282 |




| № | Батлагдсан загвар мэдээлэл | Хэмжээ | Хэмжих нэгж |
|---|---|---|---|
| 1 | Нийт газрын талбай | 4289998.42 | м2 |
| 2 | Нийт барилгажих талбай | 492056.32 | м2 |
| 3 | Төлөвлөгдсөн айл | 19072 | айл |
| 4 | Төлөвлөгдсөн ил зогсоол | 15867 | машин |
| 5 | Төлөвлөгдсөн далд зогсоол | 12999 | машин |
| 6 | Төлөвлөгдсөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний зогсоол | 499 | машин |

Сургууль цэцэрлэгийн барилгын мэдээлэл:

| | | ХУД | | | БЗД | | | НД | | | СХД | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байршил | Сурагч | хүүхэд | байршил | Сурагч | хүүхэд | байршил | Сурагч | хүүхэд | байршил | Сурагч | хүүхэд |
| Сургууль | Улс | 2 | 960 | * | 0 | 0 | * | 1 | 960 | * | 2 | 640 | * |
| | Иргэн, ААН | 2 | 1460 | * | 0 | 0 | * | 1 | 241 | * | 1 | 98 | * |
| Дүүргээр нийт | | 4 | 2420 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 1201 | 0 | 3 | 738 | 0 |
| Цэцэрлэг | Улс | 4 | * | 485 | 3 | * | 540 | 1 | * | 240 | 1 | * | 150 |
| | Иргэн, ААН | 8 | * | 789 | 2 | * | 180 | 0 | * | 0 | 0 | * | 0 |
| Дүүргээр нийт | | 12 | 0 | 1274 | 5 | 0 | 720 | 1 | 0 | 240 | 1 | 0 | 150 |
| Сургууль цэцэрлэг цогцолбор | Улс | 0 | 0 | 0 | 1 | 640 | 320 | 1 | 180 | 100 | 0 | 0 | 0 |
| | Иргэн, ААН | 9 | 3596 | 1828 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Дүүргээр нийт | | 9 | 3596 | 1828 | 1 | 640 | 320 | 1 | 180 | 100 | 0 | 0 | 0 |

| | | СБД | | | БНД | | | ЧД | | | БГД | | | НИЙТ | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байршил | Сурагч | хүүхэд | байршил | Сурагч | хүүхэд | байршил | Сурагч | хүүхэд | байршил | Сурагч | хүүхэд | Байршил | Сурагч | хүүхэд |
| Сургууль | Улс | 2 | 484 | * | 0 | 0 | * | 0 | 0 | * | 0 | 0 | * | 7 | 3044 | * |
| | Иргэн, ААН | 2 | 1250 | * | 1 | 360 | * | 0 | 0 | * | 0 | 0 | * | 7 | 3409 | * |
| Дүүргээр нийт | | 4 | 1734 | 0 | 1 | 360 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 14 | 6453 | * |
| Цэцэрлэг | Улс | 1 | * | 150 | 1 | * | 100 | 0 | * | 0 | 3 | * | 400 | 14 | * | 2065 |
| | Иргэн, ААН | 0 | * | 0 | 0 | * | 0 | 1 | * | 75 | 0 | * | 0 | 11 | * | 1044 |
| Дүүргээр нийт | | 1 | 0 | 150 | 1 | 0 | 100 | 1 | 0 | 75 | 3 | 0 | 400 | 25 | * | 3109 |
| Сургууль цэцэрлэг цогцолбор | Улс | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 820 | 420 |
| | Иргэн, ААН | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 9 | 3596 | 1828 |
| Дүүргээр нийт | | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 11 | 4416 | 2248 |

| № | Төлөвлөгдсөн барилга | Хэмжээ | Хэмжих нэгж |
|---|---|---|---|
| 1 | Сургууль | 5 | Сургууль |
| 2 | Цэцэрлэг | 12 | цэцэрлэг |
| 3 | Эмнэлэг | 9 | эмнэлэг |
| 4 | Спорт цогцолбор | 10 | барилга байгууламж, талбай, цогцолбор |

Загвар зургийн стандартын шаардлага хангуулахгүй, норм дүрэм зөрчиж зөвлөх үйлчилгээ өгч, зураг төсөл гүйцэтгэж байгаа асуудлын чанарыг сайжруулах анхааруулах зорилготой сайн, муу нэрсийн жагсаалтыг хөтөлж байгаа бөгөөд дээрх шалтгаанаар зөвшилцөх боломжгүйг загвар зургийг хөрөнгө оруулагчдын бүтээн байгуулах төлөвлөгөөт цаг хугацааг сунгахаас гадна төрийн байгууллагын үйл ажилд хүндрэл учруулж байгаа асуудлаар ерөнхий архитектороас мэдэгдэл өгч анхааруулж ажиллаж байна. Үүнд:



Муу

- “Аксиом констракшн” ХХК
- “Хотол архитектс” ХХК
- “Цэнхэр төхөм” ХХК Архитектор Ж.Баттөгөлдөр
- “Арвай нутгийн зам” ХХК Архитектор О.Үйтүмэн
- Арт капитал ХХК
- Монголын ногоон хөгжлийн судалгаа, шинжилгээ, үйлдвэрлэлийн хүрээлэн ХХК Архитектор Н.Гантулга
- Агниста инженеринг ХХК Архитектор Б.Эрдэнэбаяр
- Арт капитал ХХК Архитектор Э.Жавхлантамир
- Нарт дизайн ХХК Ц.Даваадулам
- Эм жи эл И Эн Си ХХК Архитектор Б.Билгүүн
- Кон консалтинг ХХК Архитектор О.Одончимэг
- Түм прожект ХХК Архитектор Г.Улаанхүү

Сайн

Бусад байгууллага архитекторуудад үлгэр жишээ судалгаа, гүйцэтгэл сайтай зураг төсөл хийдэг мөн өмнө нь муу жагсаалтад байсан хэдий ч сайжирч шаардлага хангаж байгаа байгууллага архитекторуудыг оруулж байна.

- “Некстстеп инженеринг” ХХК
- “Пума интернешнл” ХХК
- “ЭМ ЭС ЭЛ” ХХК Архитектор Г.Болормаа
- Вауин ХХК Архитектор С.Мөнхсайхан
- Ньюкон ХХК Архитектор Б.Батдаваа
- Марс констракшн ХХК Архитектор Н.Эрдэнэцэцэг
- Варм бюлдинг констракшн ХХК Архитектор Х.Есөн-Эрдэнэ
- Бум-Асар ХХК Архитектор А.Уянболд



5 Барилга, байгууламжийн Архитектур төлөвлөлтийн даалгаврын схем зургийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх хүсэлтийг шийдвэрлэх

Нэг цэгийн үйлчилгээний төвөөр Барилга, байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгаврын схем зургийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх 24 хүсэлт ирж шийдвэрлэгдсэн.

## *ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ*

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хариуцсан хууль тогтоомж, шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг хангаж ажиллаж, тайлагнах

   Тайлант хугацаанд доорх хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр захиргаа санхүүгийн хэлтэст хүргүүлэн ажиллав.
   Үүнд:
   - Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөрийн биелэлт,
   - Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 7 биелэлт,
   - 150 мянган айлын орон сууцны үндэсний хөтөлбөрийн 1 биелэлт,
   - Ногоон хөгжлийн бодлого үндэсний хөтөлбөрийн 1 биелэлт,
   - Шинэ Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөний санал 2,
   - Нийслэлийн Удирдах ажилтнуудын 2021 оны 11 ээлжит /цахим/ шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн 49 үүрэг даалгаврын 4 хэрэгжилт,
   - Нийслэлийн Засаг даргын захирамж, Албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгсөн 2 үүрэг даалгаврын хэрэгжилт,
   - Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийн биелэлт,
   - Короновируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх “Түр журам”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт,
   - Нийслэлийн Онцгой комиссын үүрэг даалгаврын дагуу Хан-Уул дүүргийн 11, 15, 20 дугаар хороонд байрлах томоохон захуудад болон худалдааны төвүүдэд үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн хяналтын ажлын тайлан,
   - “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээнд ажилласан 15 /эрэгтэй/ албан хаагчдын хяналтын ажлын тайлан,
   - Монгол улсын Засгийн газрын 2018 оны ”Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1016 дугаар захирамжийн хүрээнд ХУД-ийн 9, 10, 16 дугаар хороодод “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан түлшний борлуулалт, нөөцлөлтийн талаар холбогдох тайлан,
   - Нэгжийн үйл ажиллагааны 7, 14 хоног тутам сар бүрийн тайланг тус тус хүргүүлж ажиллав.

2. Хэлтсийн үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах

   Газрын "I-UP" мэдээллийн цонхоор 4 төрлийн видео мэдээг товч болон дэлгэрэнгүй байдлаар байршуулах ажлыг гүйцэтгэв.
   Байгууллага дээр ирсэн иргэн хуулийн этгээдэд дэлгэрэнгүй мэдээлэл тайлбар өгч ажиллаж байна.

3. Хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх болон газрын хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамрагдах
   - Албан хэрэг хөтлөлт, E-Doc программын хэрэглээ, Монгол улсыг хөгжүүлэх бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн талаар цахим сургалтад хамрагдсан.
   - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Нийслэлийн төсөв бүрдүүлэгч болон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын албан хаагчидтай уулзалт хийсэн.
   - ХУД, 2-р хороо нэхмэлийн шар орчим “Марта Грийн” ХХК-ийн байршилд дээр тоглоомын талбай ногоон байгууламжийн тохижилтын талбайтай газар доорх авто зогсоолын хувилбарын концепц гүйцэтгэж, нэгдсэн танилцуулга хийж, газрын удирдлага болон оршин суугч төсөл хэрэгжүүлэгч нарт танилцуулав.

4. Иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах

- Нийт 321 өргөдөл, гомдол ирснээс 316 асуудлыг шийдвэрлэсэн 5 асуудал хугацаандаа судлагдаж байна.
- 1028 албан бичиг ирүүлснийг судлан 1001 албан бичгийн хугацаанд нь шийдвэрлэсэн 27 албан бичиг судлагдаж байна.



5. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2020 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг батлагдсан хуваарьт хугацаанд холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгөх
   - 2020 оны үйл ажиллагааны явцад үүссэн 34 боть эмхэтгэн баримтыг архивд хүлээлгэн өгсөн байна.
   - 2021 оны Мэргэжлийн зөвлөлийн 1-9 дүгээр хурлаар хэлэлцэгдэн дэмжигдсэн нийт 430 байршлын хувийн хэргийг архитекторуудаас авч цахимд бүртгэлжүүлж, цахим архив үүсгэсэн эсэхийг нэг бүрчлэн хянаж, хурал тус бүрд нь хавтаст хэрэг бүрдүүлж байна.Батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгавар бүрийн 1 эх хувийг захиалагчид утсаар тухай бүрд мэдэгдэн хүлээлгэн өгсөн. 430 фолдер, 3.05 GB файл үүсгэгдсэн байна. Өнгөрсөн онуудад жилийн эцэст хувийн хэргийг цахимжуулах ажлыг хийдэг байсан бол энэ жил мэргэжлийн зөвлөлийн хурлын дараа тухай бүрд нь цахим

архив үүсгэн ажиллаж байгаа бөгөөд мэдээллийг хурдан шуурхай авах боломжийг бүрэн олгож байна.

### *ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД*

1. Хот байгуулалтын үйл ажиллагаанд Захиргааны ерөнхий хуулийн 7 дугаар бүлгийн хэрэгжилтийг ханган захиргааны сөрөг акт гарсан тохиолдолд бүртгэлжүүлэн мэдээлж ажиллана.

| д/д | Дүүрэг | Архитектур төлөвлөлтийн даалгавар | Загвар зураг |
|---|---|---|---|
| 1 | Баянгол дүүрэг | 7 | 5 |
| 2 | Сонгинохайрхан | 1 | - |
| 3 | Сүхбаатар | 1 | - |
| 4 | Хан-Уул | 1 | - |
| 5 | Нийт | 10 | 5 |

10 Архитектур төлөвлөлтийн даалгавар, 6 загвар зураг хүчингүй болгох шийдвэр гарч хууль эрх зүйн хэлтсээс сонсох ажиллагааг гүйцэтгэсэн.
Загвар зураг хүчинтэй эсэхийг мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэх асуудлыг зохион байгуулж ажиллав. /БГД-1, БЗД-2, ХУД-2, СБД-1/

2. Архитектур төлөвлөлтийн даалгаврын схем зургийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх хүсэлтийн тоог бууруулна.
Баянгол дүүрэг 1/1
Баянзүрх 4/4
Сонгинохайрхан 2/2
Налайх 1/1
Багануур 1/1
Хан-Уул 16/16
Нийт 24 хүсэлт шийдвэрлэв.

### *ТАВ. ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД*

- Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврын дагуу ХУД-ийн 11, 15, 20-р хороонд хуваарийн дагуу ажилласан.
- ХУД-ийн 15, 17, 18-р хороо, “Хүннү-2222” хороолол, “Маршалл таун” хороолол орчмын авто зам, орц гарц шинээр гаргах асуудлыг судлан танилцуулга бэлтгэсэн.
- БЗД, 4-р хороо, Маршал Г.К.Жуковын хөшөөний хойд талд, Монголын саран ээж нийгэмлэг, “Алхана трейд” ХХК нарын 5 хуулийн этгээдэд олгосон барилгын зөвшөөрлийг цуцлах асуудлыг судлан холбогдох санал, тайлбар хүргүүлж ажилласан.
- 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Нийслэлийн Засаг дарга болон холбогдох албан тушаалтнууд ажилласан бөгөөд Эрдэнийн төгөл хотхон, Маршал таун хотхон, Хан хиллс хотхон орчмын авто замын төлөвлөлт, орц, гарцтай холбоотой асуудлаар одоогийн нөхцөл байдалтай танилцаж үүрэг өгсний дагуу сургууль, цэцэрлэгийн байршлын судалгааг боловсруулан төлөвлөлтийг хийж НГЗБА-нд хүргүүлсэн болно.
- Зайсан орчмын авто замын орц, гарцын хүндрэлтэй асуудал дээр судалгаа боловсруулж НАЗХГ, НГЗБА, Богдхан уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргаанд санал авахаар тус тус хүргүүлсэн.
- Хан-Уул дүүрэгт төлөвлөгдсөн Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн орчмын барилгажилтын судалгааг хийв.

- Зураг төсөл зохиогч байгууллагуудын мэдээллийг албажуулан Барилгын хөгжлийн төсөөс гаргуулж уулзалтын зохион байгуулах газрын байршлын судалгааг гаргаж танилцуулсан.
- ХУД-17, 18-р хорооны нутаг дэвсгэрт Маршил таун хотхоны орчмын нийт 213,0 га талбарт шинээр гудамж зам гаргах, орц гарц нэмэгдүүлэх ЕБ Сургууль, цэцэрлэг барих төлөвлөлтийн зураглал боловсруулж танилцуулав.
- Туул голын эрэг дагуу Сонсголонгийн гүүрнээс Баянзүрхийн гүүр хүртэлх 27 км газарт нийт 15 байршилд тохижилт, ногоон байгууламж хийх боломжтой байршил болон Бага тойруу Д.Сүхбаатарын талбайн орчимд авто машингүй гудамж байгуулах судалгаа танилцуулга хийж газрын даргад танилцуулан ЕААА-д өгсөн.
- Барилга хот байгуулалтын сайдын А-75 журам батлагдсанаас хойш тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар авахаар ирүүлсэн хүсэлтүүдийг АТД, Боломжтой, Боломжгүй, МЗХ-д хэлэлцүүлэх гэсэн 4-н төрөлд хуваасныг МРА-д нэгтэн харуулах танилцуулга бэлдсэн.

### *ЗУРГАА. УДИРДЛАГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХҮРЭЭНД*

1. Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгавар

- “Иргэдийн амьдрах орчныг сайжруулах зарим арга хэмжээний тухай” Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/177 дугаар захирамжийн хүрээнд Баянзүрх дүүргийн Засаг даргын ахалсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан. Ажлын хэсгийг шаардлагатай мэдээллээр ханган ажиллах, шаардлагатай тохиолдолд газар дээр нь очиж танилцан холбогдох санал, дүгнэлт гаргах, илэрсэн зөрчилд шаардлага хүргүүлэх зэргээр идэвх, санаачилгатай ажилласан.

- Удирдлагаас өгсөн үүргийн дагуу Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын ахалдаг Нийслэлийн хэмжээнд орц гарцын зөвшөөрөл олгох хуралд цахимаар оролцсон.
- Газрын үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд Мэргэжлийн зөвлөлийн хурлын танилцуулга болон Загвар зургийн үлгэрчилсэн загварыг шинэчлэн газрын даргын 2021-12-10-ны өдрийн А/37 дугаар тушаал батлагдсан.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 10 өдөр Дугаар А/37 Улаанбаатар хот

Загвар зургийн үндсэн шаардлага, үлгэрчилсэн загвар батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.1.3 дах хэсэг, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн 3 дугаар хэсгийн 3.4, 3.6, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 121, 155 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл, хотын Ерөнхий архитекторын дүрэм"-ийн 3 дугаар хэсгийн 3.1.7 дах хэсэг, газрын Хөдөлмөрийн дотоод журмын 1 дүгээр зүйлийн 1.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Барилга байгууламжийн Архитектур төлөвлөлтийн даалгавартай хавсран хэвлэгдэх загварыг нэгдүгээр, Загвар зураг боловсруулах үлгэрчилсэн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан Архитектур төлөвлөлтийн даалгаврыг үндэслэн загвар зургийг боловсруулсан эсэх, үлгэрчилсэн загвар нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, нормыг хангаж байгаа эсэхэд бүртгэл хөтлөх, үлирал бүр тайлагнах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хот төлөвлөлтийн хэлтэс (С.Даланжаргал), Хот дахин хөгжүүлэх хэлтэс (М.Мэндсайхан)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Орлогч дарга (М.Шижирбаяр)-д даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2020 оны А/30 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАЗРЫН ДАРГА Ц.ТУЛГА

- Сүхбаатар дүүргийн 2 дугаар хороо “Аса” цирк орчмын 1,8 га талбай Хүүхэд залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэнг байгуулах, Одоо байгаа Н.Нацагдоржийн номын санг шинэчлэн төлөвлөж ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН СОЁЛЫН ТӨВ болгох төлөвлөлтийг боловсруулж газрын удирдлагад танилцуулав.



- Нийслэлийн хэмжээнд байгаа шинжлэх ухааны судалгаа шинжилгээ хийдэг байгууллагуудын барилга, газрын мэдээллийг нэгтгэж,бүртгэлжүүлэн тэдгээрийн үнэлгээг гарган танилцуулга бэлдэв.
- ХУД, 2-р хороо нэхмэлийн шар орчим “Марта Грийн” ХХК-д байршилд дээрээ тоглоомын талбай ногоон байгууламжийн тохижилтын талбайтай газар доорх авто зогсоолын хувилбарын концепц гүйцэтгэж, өөрийн бэлдсэн болон бусад 2 хувилбарын нэгдсэн танилцуулгын эхийг бэлдэж хийж гүйцэтгэв.
- Авлигатай тэмцэх газар болон Эрүүгийн цагдаагийн албанаас газрын даргад ирсэн албан бичгийн хүрээнд Богдхан-уулын дархан цаазат газар, хязгаарлалтын бүсэд байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллагын 28 байршлын мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн менежментийн систем болон байршил дээр хэлтсийн газрын харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Дударий, Хот байгуулалт хариуцсан мэргэжилтэн Т.Сүмбэр нартай хамтран хийж 2021 оны 10 дугаар сарын 07-ний өдөр байгууллагын удирдлагуудад танилцуулан ажиллав.
- Чингисийн өргөн чөлөө-ний буюу Төв шуудангийн аюулгүйн уулзвараас урагшаа 120 мянгатын Тэмээтэй хөшөө хүртэлх 1,9 км авто замыг 6 эгнээтэй болгон шинэчлэх, Энх тайвны гүүрийг шинэчлэн, засварлаж  2 талаар нь унадаг дугуйтай болон явган зорчигчийн гүүр шинээр хийж тус гүүрний сонгодог хэв загварыг орчин үеийн чиг хандлагатай болгон шинэчлэх зураг төслийн судалгааг танилцуулав.



- Авто замын түгжрэлийг бууруулах талаар авто замын сүлжээ нэмэгдүүлэх, дугуйн замын сүлжээг холбох, нүхэн болон гүүрэн гарцын байршлыг нэмэгдүүлэх талаар танилцуулга боловсруулж газрын дарга болон Нийслэлийн удирдлагуудад танилцуулсан.




- НЗД 2021-05-20-ны өдрийн А/374 дугаартай Эко орчин-цэвэр агаар" аян зохион байгуулах ажлын хэсгийн хуралд орж санал өгч гудамжны тохижилтын судалгааг боловсруулах ажлыг зохион байгуулж Баянгол, Чингэлтэй дүүрэгт Гандангийн зүүн хойд уулзвараас хойд зүг Эх нялхсын эрүүл мэндийн төвийн уулзвар хүртэл, Баянгол Сонгинохайрхан дүүрэгт Саппорогийн аюулгүйн уулзвараас хойд зүгт 3, 4-р хорооллын эцсийн автобусны буудал хүртэл гудамж, Хан-Уул дүүрэгт "Улаанбаатар

цахилгаан түгээх" ХК-аас хойд зүг Үйлдвэрчний гудамж хүртэл, Сүхбаатар Чингэлтэй дүүрэгт 32-ын аюулгүйн уулзвараас хойд зүг 5 буудал хүртэл, Баянзүрх дүүрэгт Дандарбаатарын гудамж буюу Скадрилын хөшөөнөөс хойд зүг Цайз захын уулзвар хүртэл байна.

7 сар 28, 2021 admin 195



- Нийслэл Улаанбаатар хотын авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх, авто зогсоолоос шалтгаалаг замын хөдөлгөөний ачааллыг бууруулах, автомашины зөв хэрэглээг бий болгох, нэг стандартыг нэвтрүүлэх, авто зогсоолын нэгдсэн системд шилжүүлэх ажлын хүрээнд танилцуулга судалгааг нэгтгэв.




- "Залуус" орон сууцны хорооллуудыг байгуулах дэд ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, Ажлын хэсгийн хурлаас шуурхай үүрэг даалгавар өгсний дагуу "Барилгажилтын төслийн урьдчилсан ТЭЗҮ, эх загвар зураг" боловсруулахаар шалгарсан "Нийслэлийн Зураг төсөл, судалгааны институт" ОНӨААТҮГ-т инженерийн дэд бүтцийн хангагч байгууллагууд, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газрын саналуудыг нэгтгэж хүлээлгэн өгсөн.

- Газрын удирдлагаас өгсөн Улаанбаатар хотын төвийн Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт авто зогсоолоор ашиглах боломжтой газруудын судалгаанд Их тойруу орчмын мэдээллийг бэлтгэн өгч ажиллав.
- Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Цагдаагийн ерөнхий газар тээврийн цагдаагийн албаны конторын зориулалттай барилгын байршлыг судлан танилцуулга бэлтгэж өгсөн.
- Газрын удирдлагаас өгсөн Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12 дугаар хороо, “Орон сууцны 7 дугаар нэгж хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тус байршилд барилгажилтын төсөл хийх үүрэг даалгаврын дагуу барилгажилтын төслийн судалгаа, газар зохион байгуулалтыг хийж гүйцэтгэн 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдөр танилцуулсан.
- Нийслэлийн Засаг даргын А/177 дугаар захирамжийн биелэлтийг хангах ажлын хүрээнд барилгын байршлаар газар дээрх судалгаанд явж 41 барилгад барилгын түр хашааны стандартад нийцүүлэх шаардах хуудас хүргүүллээ.
- 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн А/27 дугаар тушаалаар батлагдсан “Манай хороо-Миний гудамж” аяны ажлын хэсэгт идэвхтэй ажилласан.
- ХУД-ийн 15, 17, 18-р хороо, “Хүннү-2222” хороолол, “Маршалл таун” хороолол орчмын авто зам, орц гарц шинээр гаргах асуудлыг судлан танилцуулга бэлтгэсэн.
- “Авто зогсоол, орц гарц, хүүхдийн тоглоомын талбай шийдвэрлүүлэх, зөвшөөрөлгүй барилга угсралтын ажил хийгдэж байгаа тухай” БЗД, 5-р хорооны нутаг дэвсгэрт, Тарвалин хийдийн хойд талд, Поларис аппартмент хотхоны оршин суугчдаас НЗД-д хандан гаргасан гомдлын дагуу газар дээр нь очиж танилцаж, төсөл хэрэгжүүлэгч “Марч констракшн” ХХК-д шаардлага хүргүүлсэн. Одоогоор төсөл хэрэгжүүлэгчээс авто зогсоол, орц гарцын асуудлыг шийдвэрлэхээр иргэдтэй гэрээ, хэлцэл хийсэн тухай албан бичиг ирүүлсэн.
- БЗД, 4-р хороо, Маршал Г.К.Жуковын хөшөөний хойд талд, Монголын саран ээж нийгэмлэг, “Алхана трейд” ХХК нарын 5 хуулийн этгээдэд олгосон барилгын зөвшөөрлийг цуцлах асуудлыг судлан холбогдох санал, тайлбар хүргүүлж ажилласан.

**ОЛОН НИЙТИЙН АЖИЛ:**

- Барилгын чанар, аюулгүй байдал хяналтын хэлтэст зөрчилтэй 116 барилгын судалгаанд Чингэлтэй дүүргийн гэр хорооллын нутаг дэх байршилд мэдээлэл, санал өгч ажилласан.
- “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны төлөвлөгөөнд хот дахин хөгжүүлэх ажлын хүрээнд хийгдэх ажлын төсөлд санал өгч ажилласан.
- “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал”-д ажил, мэргэжлийн зүгээс санал өгсөн.
- Дэм дэмэндээ аянд нэгдэн зорилтот өрхөд хандив өгсөн.
- “Хүүхдийн төлөө фонд”-д нэгдэн 1 өдрийн цалингаа хандивласан.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлэх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн СХД-ийн 24 дүгээр хороо, Баруун салаа Бумбатын рашааны талбайд 80 ширхэг мод тарих арга хэмжээнд оролцов.
- "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" ОНӨТҮГ-тай мод тарих талаар Хамтран ажиллах гэрээ байгуулан байгууллагын нэрэмжит төгөл байгуулах ажлын эхлэх болох “Намрын мод тарих өдөрлөг “ арга хэмжээнд оролцон мод тарьсан.
- Газрын спорт хамтлагаас зохион байгуулсан “Хөдөлгөөнөөр дархлаагаа дэмжье” уриатай спортын 6 төрөлт тэмцээнд амжилттай оролцсон.
- Газрын албан хаагчдын хамт 2021 оны 10 сарын 16-наас 23-ны өдрүүдэд эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдав.

**САНААЧИЛСАН БҮТЭЭЛЧ АЖЛЫН ХҮРЭЭНД**

1. Байгууллагын нэр бүхий Зуслангийн газарт нэгдсэн төлөвлөлт бүхий албан хаагчдын хүсэл сонирхолд нийцсэн барилгын загвар зургийн уралдаан зохион байгуулж 2 сарын хугацаанд 7 оролцогчийн 12 төрлийн загвар бүтээлээс шилдэг бүтээлүүдийг шалгаруууллаа. Уралдаанд: Тэргүүн байр - Н.Төгөлдөр,
Дэд байр - Э.Тэмүүлэн, Тусгай байр - С.Үүрцайх, Д.Өлзийжаргал нар шалгарсан.




2. Хүртээмжтэй төсөл /Налуу зам/ -ийн хүрээнд өмнөх онуудад хийсэн зураг төслийг хэрэгжүүлэх асуудлаар EAGLE телевиз, UBS, MYOHP Телевиз болон цахим хуудсаар олон нийтэд мэдээлэл өгч ажилласан бөгөөд “Төв шуудан”-гийн барилгад үйл ажиллагаа явуулж байгаа “Монгол шуудан” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХК, “Монголын цахилгаан холбоо” ХК хүртээмжийн төслийг дэмжин налуу замаа стандартын шаардлага хангуулан гүйцэтгэлээ. Мөн 2021-05-21-ны өдөр Газрын дарга бөгөөд Улаанбаатар хотын ерөнхий архитектор холбогдох нэгжийн дарга “Монголын Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо”-ны тэргүүн Б.Чулуундолгортой уулзаж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийн чиглэлээр хийх сургалт болон байгууллагын ажлын чиг үүргээр хүртээмжийн чанарыг хэрхэн анхаардаг талаар харилцан мэдээлэл солилцов. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийн чиглэлээр хамтран ажиллах боллоо. Мөн тус ажлыг 2022 оны Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулахаар санал өгөв.
3. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд байгууллагын нэрэмжит болгон тохижуулах 1,0 га талбайн тохижилтын ажлын зураг төслийг санаачлан боловсруулж батлуулав.





4. Газрын үйл ажиллагааг улам нээлттэй хурдан шуурхай болох зорилготой **i-UP мэдээллийн цонх-**ыг албан ёсоор эхлүүлж Мэргэжлийн байгууллагын хийсэн судалгаа, мэдээлэл, зөвлөмжийг олон нийтэд видео хэлбэрээр хүргэж эхлүүлэв. i-UP мэдээллийн цонхоор “Нийтийн тээврийн сонголтоор Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах””Архитектур төлөвлөлтийн даалгавар олгох” “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг шинэчлэн барилгажуулах төсөл”, ”Хүртээмжийн төсөл–Налуу зам” зэрэг мэдээллийг гаргав.



5. “Чанга тэврэлт” Мэдээллийн цагийг эхлүүлсэн. Нэгжийн хамт олныг ажлын идэвх, дотно уур амьсгалыг нэмэгдүүлэх бие биесээ илүү ойлгох зорилготой бөгөөд Өөрийн судалсан ном, бүтээл, шинэлэг мэдээллийг бусдадаа мэдээлж өөрийгөө

хөгжүүлэх мэдээллийн цагтай болж манлайллын онолын хөгжөөнт дасгал хийж “Сэтгэх урлаг” хомын талаар мэдээлэл хийж эхлэв.






- Баянгол дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт Гандантэгчинлэн хийд орчим, баруун 4 замаас тасганы уулзвар хүртэлх 55.8 га талбай, 1.3 км урт үргэлжлэх соёлын гудамжны байршлын судалгаа, одоогийн байдалтай уялдуулах төлөвлөх саналыг боловсруулсан.

# СОЁЛЫН ГУДАМЖ ГАНДАН ОРЧИМ



ХОТ БАЙГУУЛАЛТ ХӨГЖЛИЙН ГАЗАР

*ТАЙЛАН ХЯНАСАН:*

Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга ......................... / С. Даланжаргал /

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

............................ *(огноо)*

*ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН::*

Ахлах мэргэжилтэн ......................... / Д. Хан-Уул /

Ахлах мэргэжилтэн ......................... / Б. Батцолмон /

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

............................ *(огноо)*